



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 06.

Тавин

Хоршоог хөгжүүлэх сангийн 2022 оны  
зээл олгох салбар чиглэл батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь заалт, хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3, 3.3.4, 3.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Засгийн газрын бодлого, төсөл хөтөлбөртэй уялдуулан, сумын зээл олгох салбар, чиглэлийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан салбар, чиглэлийн дагуу төслийг сонгон шалгаруулж, ажиллахыг сумын Засаг дарга ( Ч.Уранчимэг )- т үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт

Зээл олгох салбар, чиглэл

1. Зочид буудал, зоогийн газар
2. Барилга, засвар үйлчилгээ
3. Арьс шир, түүхий эд боловсруулах
4. Сүү, сүүн бүтээгдэхүүн
5. Газар тариалан, ногоон байгууламж
6. Мах, махан бүтээгдэхүүн
7. Хими цэвэрлэгээ, ахуй үйлчилгээ
8. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэл
9. Хоёр дахь түүхий эд боловсруулах
10. Аялал жуулчлал